

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ 2011-2023

Хавдар судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлд 2011-2021 оны хооронд тус төвийн болон гадны 32 эрдэмтэн ажиллаж ирсэн. Эрдэмтдийн дотор академич (4), профессор (5), дэд профессор (5), доктор (18) байгаа ба Эрдмийн зөвлөлийн даргаар Анагаах ухааны доктор Г.Пүрэвсүрэн (2011-2016), Анагаах ухааны доктор Ж.Чинбүрэн (2017-2019), Анагаах ухааны доктор, дэд профессор Н.Эрдэнэхүү (2020 оноос одоог хүртэл), Эрдэмтэн нарийн бичгийн даргаар Анагаах ухааны доктор, профессор Д.Авирмэд (2011-2013), Анагаах ухааны доктор Ц.Бадамсүрэн (2014 оноос одоог хүртэл) нар томилогдон ажиллаж ирсэн /Хавсралт 1/.

Энэ хугацаанд нийт 17 удаагийн ээлжит ба ээлжит бус хурлыг хуралдуулж, 50 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсний дотор:

- Хавдар судлалын судалгааны тэргүүлэх чиглэлийн санал-6
- Хорт хавдрын судалгааны үндэсний хөтөлбөр (2015-2025)-1
- ШУТС-гийн төслийн хэрэгжилт (7), захиалгат төслийн санал-(3)-10
- Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтын эрх авах-6
- Хавдрын тусламж үйлчилгээний салбарт оношилгоо, эмчилгээний удирдамж, стандарт, арга, аргачлал-5
- Докторант (2), магистрант (10), оюутан (1) судалгааны арга аргачлал-13
- Олон улстай хамтарсан болон МУ-д хийгдэж байгаа судалгааны арга аргачлал-5
- Шилдэг залуу эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдад олгох МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал болон Монголын анагаах ухааны салбарын оны шилдэг судалгааны баг, судлаач, бүтээл шалгаруулалтанд нэр дэвшүүлэх-2
- ХСҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн Хүндэт доктор цолоор өргөмжлөх-1
- Хавдар судлалын салбарын 60 жилийн ойн ЭШХ-ын танилцуулга-1



Ерөнхий захирлын 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн тушаалаар “Эрдмийн зөвлөлийн дүрэм”-ийг баталсан. Энэхүү дүрмийн зорилго нь Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан ХСҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулахад оршино. Дүрэмд зааснаар Эрдмийн зөвлөлийг Эрдмийн зөвлөлийн дарга, Эрдэмтэн нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр жил бүр Ерөнхий захирлын тушаалаар батлах ба Эрдмийн зөвлөл нь өөрийн эрх, үүргийн хэмжээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ, гишүүдийн ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан, хэлэлцэх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэхэд энэхүү дүрмийг мөрдлөг болгохоор заасан.

ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/37 тоот тушаалаар Эрдмийн зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлан хэрэгжүүлж байна.